

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өвөрхангай аймаг дахь Нисэх буудлын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ӨВА-2023/01/НА-СТА-ТӨА

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a>	Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: О.Батжаргал Утас: 70323253 Цахим хаяг: BatjargalO@audit.gov.mn
Арвайхээр хот	Аудитын менежер: Д.Гансүх Утас: 70323833 Цахим хаяг: GansukhD@audit.gov.com
2023 он	Ахлах аудитор: Б.Эрдэнэцэцэг Утас: 70323108 Цахим хаяг: Erdenetsetsegb@audit.gov.mn
	Аудитор: Э.Энхбаяр Утас: 70323833 Цахим хаяг: Enkhbayare@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт /Баталгаажсан хувийг оруулах/**



**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ТӨРНИЙ АУДИТЫН ТАГААР**

Төрийн аудитын тухай хууль, Төсвийн тухай хууль, Өвөрхангай аймаг дахь Нисэх буудлын тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Өвөрхангай аймаг дахь Нисэх буудлын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Өвөрхангай аймаг дахь Нисэх буудлын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

ИНУТ-ын харьяа Өвөрхангай аймаг дахь салбар нь Арвайхээр, Хархорин, Хужирт нисэх буудал болон Богд-Далан олон улсын өнгөрөлтийн станц гэсэн 4 салбар нэгжтэйгээр үйл ажиллагаа явуулдаг. Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд Иргэний нисэхийн үндэсний төв Төрийн өмчит ААТҮГ, Иргэний нисэхийн Ерөнхий газрын харьяа Өвөрхангай нисэх буудал гэсэн статустай өмчийн 100 хувийг төр эзэмшиж байна. Өвөрхангай аймаг дахь Нисэх буудал нь 2022 оны төсвийн гүйцэтгэлээр улсын төсвөөс 873.4 сая төгрөгийн санхүүжилт авч 1.1 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, нийт 874.2 сая төгрөгийг зарцуулсан байна. Үүнд Ажиллагсадтай холбоотой зардалд 626.5 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой гэрэл цахилгаан, түлш халаалт, цэвэр бохир усны зардалд 339 сая төгрөг, хангамж, бараа материалын зардалд 35.5 сая төгрөг, томилолтын зардалд 5.6 сая төгрөг, газрын татварын зардалд 77.1 сая төгрөг, даатгалын үйлчилгээний зардалд 14.4 сая төгрөгийг тус тус зарцуулжээ. ИНЕГ-ын даргын 2022 оны А/104 дугаар тушаалаар байгууллагын орон тоог шинэчлэн баталсан боловч Монгол улсын агаарын зайд нислэг үйлдэж буй өнгөрөлтийн нислэгийн тоо эрс буурч, эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл байдал, ажлын байрны ачаалал багассантай холбогдуулан 2022 оны 11 сарын 7-ны өдрөөс 12 сарын 31-ний өдрийг хүртэл сул зогсолт хэсэгчлэн зарласан байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудлууд нь бидний мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайланд хийсэн бидний аудитад хамгийн их анхаарал татсан асуудалд байна. Бидний гаргасан тайланд материаллаг хэмжээний аудитын гол асуудал байхгүй хэмээн тодорхойлж байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Удирдлага бусад мэдээллийн хувьд хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл нь жилийн тайланд орсон мэдээллээс бүрддэг боловч түүнд санхүүгийн тайлан болон аудиторын тайлан багтаагүй байж болно. Бидний санхүүгийн тайланд өгсөн дүгнэлт нь бусад мэдээлэлд хамаарахгүй ба бид уг мэдээлэлд аливаа баталгаа илэрхийлээгүй.

Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотойгоор бид бусад мэдээллийг унших үүрэгтэй учраас уг мэдээлэл нь санхүүгийн тайлантай материаллаг байдлын хувьд нийцэж байгаа эсэхийг авч үзнэ. Хэрэв бид хийсэн ажилдаа үндэслэн бусад мэдээлэлд материаллаг буруу тайлагнал байна гэж дүгнэсэн бол энэ байдлыг тайландаа тусгах ёстой. Аудитын явцад бид энэ талаар тайлагнах шаардлага үүсээгүй.

### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



О. БАТЖАРГАЛ

## Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

	Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31.
<b>Санхүүгийн байдлын тайлан</b>			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	29,953.5	41,071.3
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	49,530,443.4	51,114,920.3
	<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>49,560,396.9</b>	<b>51,155,991.7</b>
	Нийт өр төлбөрийн дүн	-	-
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	49,560,396.9	51,155,991.7
	<b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>49,560,396.9</b>	<b>51,155,991.7</b>
<b>Санхүүгийн үр дүнгийн тайлан</b>			
	Үйл ажиллагааны орлогын дүн	946,035.7	1,921,587.6
	Үйл ажиллагааны зардлын дүн	1,045,825.0	1,045,804.3
	<b>Үйл ажиллагааны үр дүн</b>	<b>(99,789.3)</b>	<b>875,783.3</b>
	Үйл ажиллагааны бус үр дүн	-	-
	<b>Үйл ажиллагааны нийт үр дүн</b>	<b>(99,789.3)</b>	<b>875,783.3</b>
<b>Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан</b>			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	49,660,186.1	49,560,396.9
	Тайлант оны үр дүн	(99,789.3)	875,783.3
	<b>Эцсийн үлдэгдэл</b>	<b>49,560,396.9</b>	<b>51,155,991.6</b>
<b>Мөнгөн гүйлгээний тайлан</b>			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	827,231.9	875,539.6
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	827,184.4	874,291.3
	<b>Үйл ажиллагааны ЦМГ</b>	<b>47.6</b>	<b>1,248.3</b>
	<b>Хөрөнгө оруулалтын ЦМГ</b>	<b>-</b>	<b>-</b>
	<b>Санхүүгийн ажиллагааны ЦМГ</b>	<b>-</b>	<b>-</b>
	<b>Нийт цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>47.6</b>	<b>1,248.3</b>
	Мөнгө, түүнтэй адилтах хөрөнгийн эхний үлдэгдэл	302.0	349.6
	Мөнгө, түүнтэй адилтах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	349.6	1,597.9
<b>Төсвийн гүйцэтгэлийн тайлан</b>			
	<b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>	<b>-</b>	<b>-</b>
	Урсгал зардал	-	-
	Хөрөнгийн зардал	-	-
	<b>Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр</b>	<b>-</b>	<b>-</b>
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	-
	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	-	-
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	-	-
	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	-
	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	-	-

### Гурав. Аудитын илрүүлэлт:

5.1 Төлбөрийн акт

Аудитаар зөрчил илрээгүй

5.2 Албан шаардлага

Аудитаар зөрчил илрээгүй

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.  
Үүнд:

1. Анхан шатны баримттай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Хүчингүй болсон Санхүү, Эдийн засгийн сайд, Үндэсний статистикийн газрын даргын 2002 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн 171/111 дугаар тушаал, Санхүү, Эдийн засгийн сайдын 2002 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 182 дугаар тушаалуудаар тус тус баталсан анхан шатны баримтуудаар нягтлан бодох бүртгэл хөтөлж байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар шинэчлэгдэн баталсан анхан шатны баримтуудаар хөтөлж байх гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх заалт, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан "Маягт, заавар батлах тухай" журмыг тус тус мөрдөж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 5 дугаар сарын 01 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

**Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/ сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Үүнээс		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Хариуцлага тооцуулах албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Нисэх буудал	1	0					1	0				
Дүн	1	0					1	0				

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/сая төгрөгөөр/

	Нийт зөрчил	Үүнээс

Аудитад хамрагдсан байгууллагын нэр			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ								
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	<b>НИЙТ</b>								

**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

6217143681  
ИЮА0059 9044094